



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/22 ДУА-2018/119/СТА-ТЦЗ

Мандалговь хот

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгохдоо батлагдсан орон тооноос 5 орон тоогоор хэтрүүлэн **356,000.00** /Гурван зуун тавин зургаан мянган/ төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, 16.5.3-д /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, Монгол улсын их хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.а-д /Бүх шатны төсөв захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Батлагдсан орон тоо хэтрүүлэн олгосон **356,000.00** /Гурван зуун тавин зургаан мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Бүрэн дунд сургуулийн захирал Л.Буянтогтох, нягтлан бодогч Д.Ууганбаяр нарт хариуцуулав.

**АКТЫГ**


**ТОГТООСОН<sup>1</sup>:**

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ



**ЗӨВШӨӨРСӨН:**

ЗАХИРАЛ  Л.БУЯНТОГТОХ  
НЯГТЛАН БОДОГЧ  Д.УУГАНБАЯР



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.